

ДУНДГОВЬ АЙМГИЙН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ, МАЛЧДЫН НҮҮДЛИЙН ХЭВ ШИНЖ

А.Батжаргал, Д.Мөнхзул

Геоэкологийн хүрээлэн, Газрын нөөц, газар ашиглалтын салбар

Abstract

There has been a decrease in adequate pastureland caused by the alteration of traditional technology. In some areas, large amounts of herdsmen and livestock are concentrating in a particular area resulting in pastureland degradation.

Some negative problems of animal husbandry such as abandoned pastureland, plundered yards and wells and pastureland disputes have contributed to intensifying pastureland degradation.

The present pastureland situation in Dundgobi aimag is described by grazing around only one well throughout all seasons of the year. This is the principal cause of pastureland degradation in this aimag, that is, pastureland grazing without rotation.

There is 2110 hectares of pastureland area that can not be utilized. Of this, desertification, degradation and decrease in plant cover have affected 765 hectares. The other 1345 hectares has experienced a loss in carrying capacity.

The excess of lost carrying capacity is not evident in the whole area of this aimag. There is too much livestock clumping in some areas and in others pastureland stress is comparatively little.

Оршил

Өнөөдөр манай малчид олон зуун жилийн хөгжлийн явцад бүрэлдэн тогтсон бэлчээр ашиглалтын уламжлалт аргыг орчин үеийн нөхцөлд тохируулан ашиглах шаардлагатай болж байна. Мал хувийн өмчид шилжсэнээр малчин өрхийн амьжиргааны ганц эх үүсвэр нь бэлчээрийн мал болсноор тэд зах зээлийн өрсөлдөөнд сөхрөхгүйн тулд малынхаа тоог өсгөх сонирхолд хөтлөгдөж, бэлчээрийг хуваарьтай ашиглах, малаа оторлуулан таргалуулах, бэлчээрийн багтаамждаа тохируулан малынхаа тоог хязгаарлах, нутагладаг нутгаа хамт олноороо зөвшилцөн ашиглах зэрэг бэлчээрийн менежментийн наад захын зохицуулалтыг орхигдуулж байна [3].

Нөхцөл байдал нь ийнхүү өөрчлөгдөж байгаагаас бэлчээр ашиглалтын уламжлалт тогтолцоо мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх боломжийг бүрдүүлж чадахгүй байна. Дээрх байдлыг судлах, цаашдын төлөв байдлыг тодорхойлох зорилгоор манай оронд сүүлийн жилүүдэд гадаад, дотоодын олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаагийн нэг нь манай төсөл юм. Төслийн хүрээнд хийсэн ажлын товч үр дүнгээс энэ өгүүлэлд оруулсан болно.

Бэлчээр ашиглалт буюу судалгааны үр дүн

Дундговь аймаг нь нийт 7469.0 мян га нутаг дэвсгэртэй бөгөөд үүнээс бэлчээрийн газар 7160.9 мян га буюу нийт нутгийн 95 хувийг эзэлж байна.

Тус аймгийн бэлчээр ашиглалтын байдлыг судлах явцад бэлчээр ашиглалтын уламжлалт аргаас үүдэлтэй дараах сул талууд ажиглагдаж байна. Үүнд:

- Худаг ус, ургац сайтай, зах зээлд ойр зэрэг ашигтай бэлчээрт олон өрх, мал ямар ч зохицуулалтгүй дураараа бөөгнөрснөөс малын бэлчээрийг талхдагдалд оруулж, бэлчээрийн хүрэлцээг муутгаж байна.
- Бэлчээрийг хуваарь, сэлгээтэй ашигладаггүй
- Бороо хур энд тэнд хэсэгчлэн ордгоос бага талбайд ургаж эхэлж байгаа ногоог ургах шатанд нь олон өрх бөөгнөрөн бууж цөлмөн иддэгээс дундын эзэмшилд байдаг бэлчээрийн үр жимс нь боловсорч амжилгүй дараа дараагийн жилд сэргэн ургах нөхцлийг хязгаарладаг.
- Бэлчээрийн газрыг албан ёсоор гэрээ хийж, ашиглах эрх олгоогүйгээс өвөлжөө, хаваржааны хавийн бэлчээрийг нь өөр малчид малдаа идүүлэх явдал их гардаг. Үүнээс болж малчдын хооронд газрын маргаан үүсдэг.
- Нөгөө талаас малчид өвөлжөө, хаваржааны бэлчээрээ хамгаалах үүднээс холын оторт явахад больж, тэр хавийн бэлчээрээ сэргээх боломж өгдөггүй.

Тус аймгийн бэлчээрийн нийт газрын 71.7 мян га автогенийн нөлөөллөөс, 99.3 мян га нь хортон мэрэгчид тархсан, 88.4 мян га элсний нүүлтэд нэрвэгдсэн, 108.1 мян га нь усны эвдрэлд орсон, 1327.3 мян га газар талхлагдаад байна. Энэ нь нийт бэлчээрийн газрын 23.6 хувь нь болох юм. Гэтэл малаа өсгөх, хөгжүүлэх малчдын сонирхол, бэлчээрийн хүрэлцээний хоорондын зөрчил нь дараах хэд хэдэн шалтгаантай байна. Үүнд:

- Тус аймагт хуурайшилт эрчимтэй явагдаж, бэлчээрийн ургамлын бүтэц, хэмжээ урьдынхаас эрс буурсан, ган, зудын давтамж ойртохын зэрэгцээ их газар нутгийг хамрах болсон
- Бэлчээр нутаг ашиглах сонгомол нүүдлийн технологи алдагдаж малчдын бэлчээр ашиглах радиус багасч нэг буурин дээр удаан суурьшдаг болсон нь бэлчээрийн даацыг бууруулж улмаар талхлагдалд нөлөөлөх хүний үйл ажиллагааны гол хүчин зүйл болдог.
- Хэрэглээгээ малчид малынхаа тооны өсөлтөөр хангахаас өөр аргагүйд хүрч, малаа өсгөх ихээхэн сонирхолтой болсон. Энэ сонирхол нь малыг өсгөх хүчин зүйл болохын хамт эргээд бэлчээрийн хомсдолд хүргэж байна.
- Зах зээлд шилжих жилүүдэд малын хашаа, бэлчээрийн усны эх үүсвэрийг ухамсаргүйгээр устгаснаас ихээхэн хэмжээний бэлчээр ашиглалт багатай болсон.
- Үлийн цагаан оготно, царцаа, голио, эрвээхэй тархаж бэлчээрийн чанарыг муудахад хүчтэй нөлөөлж байгаа бөгөөд бэлчээрийн эдгээр хортонтой тэмцэх хүч хүрэхгүй, арга мухардаж байна.

Зураг 1. Дундговь аймгийн бэлчээрийн төлөв байдал

Бэлчээрийн хүрэлцээ, даац хэтэрсэн, цөлжсөн, үлийн цагаан оготно, царцаа, голио тархсан, бэлчээрийн чанар муудсан сумуудад энэ ажил нэлээд эрчимтэй өрнөж байна.

Адаацаг, Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэрэн, Говь-Угтаал, Луус сумдад бэлчээрийн даац 34.0-88.8 хувь хэтэрсэн байна. Гэхдээ бэлчээрийн даац хэтрэлт эдгээр сумдын нутаг дэвсгэрийн бүх хэсэгт биш, харин зарим газарт мал хэт төвлөрч, зарим газар нь харьцангуй бага ачаалалтай байна (Зураг 2.).

Нутаг бэлчээр хүрэлцээгүйгээс ашигтай бэлчээрийг даган аймаг, сум дамжин нутагладаг малчдын тоо Дундговь аймагт их байдаг.

Бэлчээрийн ашиглалтын менежментийн нэг чухал хэсэг нь малчдын нүүдлийн хэв шинж юм. Дундговь аймгийн бэлчээр ашиглалтын хэв шинж одоогийн байдлаар хээрийн бүсэд багтдаг сумдад 4 улирлын ба 2 улирлын сэлгээ холилдож байгаа боловч ерөнхий хандлага нь өвөл-хавар, зун-намар гэсэн хэв шинж рүү их хурдтайгаар шилжиж байна. Говийн сумуудад бэлчээрийг өвөл-хавар, зун-намар гэсэн хоёр улирлаар ашиглах хэв шинж зонхилж байна (Хүснэгт 1).

Хүснэгтээс үзвэл, судалгаанд хамрагдсан 3911 хот айлын 88.7% нь өвөл, хаврын улирлыг нэг өвөлжөөнд өнгөрүүлдэг бол 11.3% нь л өвөлжөөнөөс хаваржаа руу нүүдэг байна. Харин зуслан, намаржаа нь тусгай байдаг хот айл дөнгөж 2.7%-ийг эзэлж байна. Эндээс үзвэл Дундговь аймгийн нийт бэлчээр бараг бүхэлдээ дөрвөн улирлын ашиглалттай байна.

Нийт малчид цаг агаарын хэвийн нөхцөлд усаа дагаж, жилдээ 2-4 удаа богино зайд (2-15км) нүүдэллэдэг. Түүгээр ч барахгүй нутгийн хойт хэсгийн малчид худгийнхаа ойролцоо өвөлжөө бууцан дээрээ байшин барьж суурьших хандлага эхэлж байна. Малчдын суурьших хандлагыг аж

төрөх ёсны хөгжлийн үүднээс авч үзвэл дэвшил мэт боловч бэлчээрийн менежментийг илүү боловсронгуй болгох шаардлага байгааг харуулж байна.

1 дүгээр хүснэгт

Дундговь аймгийн малчдын нүүдлийн хэв шинжийн судалгаа

ä/ ä	Ñoi äüí í ýðñ	^a ä° ä- öäääð	^a ä° äæ°°	Öäääðæää	Çóí - í àì äð	Çóñeái	í àì äðæää
1	Ýðäýí ýääeäe	517	39	39	556		
2	Ääääöää	210	84	84	270	24	24
3	Ööeä	250	24	24	274		
4	^a äçeéð	328	25	25	353		
5	Äýeäýðöái ääe	251	4	4	255		
6	Äýöýí	143	65	65	179	29	29
7	Ñäeí öäääái	318	17	17	335		
8	Ääýí æäðääeái	119	24	24	143		
9	Äýeäýðöí äð	197	18	18	215		
10	Ñäeöái -î äí î	278	14	14	292		
11	Äí äü-Ööääe	151	31	31	182		
12	Öäääái äýeäýð	120	22	22	134	8	8
13	Ëóóñ	206	21	21	219	8	8
14	^a í ä° äð èè	138	11	11	112	37	37
15	Äóðäái ñäeöái	242	44	44	286		
	Äçí	3468	443	443	3805	106	106

Харин ган зуд тохиолдсон үед аль өнтэй зунтай нутгийг дагаж аймаг, сум дамжсан холын отор нүүдэл хийнэ. Дундговь аймагт цаг агаарын эрсдэл тохиолдох давтамж богино, нэгэнт л ган зуд болсон бол ойр орчимд нь бэлчээрийн боломж мөн алдагддаг учраас малчид нь холын отор нүүдэл хийх дадлага, туршлагатай, байнгын бэлэн байдалд байдаг онцлогтой.

Хэдийгээр аймгийн хэмжээгээр бэлчээр нутгийн хүрэлцээ сайнгүй боловч бэлчээр усны маргаан хурцдах хэмжээнд хүрээгүй, одоогийн байдлаар малчдын хоорондын зохицоогоор шийдвэрлэгдэх боломжтой байна.

Дүгнэлт

1. Бэлчээрийг хуваарь сэлгээтэй ашиглах уламжлалт технологи алдагдсанаас бэлчээрийн хүрэлцээ муудах, зарим нутагт мал, хүн ихээр бөөгнөрч, бэлчээр талхлагдахын хамт зарим бэлчээр эзэнгүйрэх, хашаа, худаг тоногдох зэрэг сөрөг нөлөөтэй үзэгдлүүд идэвхжих хандлагатай байна.
2. Бэлчээрийн менежментийг газар нутгийн онцлогт нь тохируулан боловсронгуй болгох чиглэлээр малчид малчдын бүлэг, баг, сум, аймгийн зүгээс нэгдсэн зохицуулалт бүхий арга хэмжээ нэн даруй авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
3. Сум, баг, малчдын бэлчээр ашиглалтын хэсэг бүлэг бүрээр бэлчээрийн даац, ачааллыг судалж, малын тоо толгойг бэлчээрийн даацад нь тохируулан өсгөхийн чухлыг малчдад сурталчилж ойлгуулах хэрэгтэй.
4. Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх, уст цэгийн тоог олшруулах, бэлчээрийг малчдын өөрсдийн нь хүч боломжид тулгуурлан хамгаалах сайжруулах арга хэмжээ авах, бэлчээрийг хуваарь сэлгээтэй ашигладаг журамд шилжих зэргээр бэлчээр ашиглалтыг боловсронгуй болгох арга хэмжээнүүдийг ойрын хугацаанд хэрэгжүүлж, цаашид урт хугацааны бодлого боловсруулах хэрэгтэй болжээ.

Ашигласан ном, хэвлэл

- [1] Д.Энхтайван, С.Шийрэв-Адъяа *Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудалд* Монгол орны газарзүйн асуудал Улаанбаатар 2003
- [2] *Газрын нэгдмэл сангийн тайлан* Улаанбаатар 2003 он
- [3] С.Цэрэндаш, А.Энх-Амгалан, С.Шийрэв-Адъяа *Монгол улсын тогтвортой хөгжил дэх бэлчээрийн тулгамдсан асуудлууд* Монгол орны газарзүйн асуудал Улаанбаатар 2003 он
- [4] Монгол улсын их хурлын албаны мэдээлэл *Төрийн мэдээлэл №9/342/ 2004.03.05* Улаанбаатар хот